


“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2026 оны 02 дугаар сарын
09-ны өдрийн 1/а дугаар тоот тушаалын хавсралт



АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар шинэчлэн батлагдсантай холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

2026 оны 3 дугаар сарын 01-ний өдөр

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан огноо:

2026 оны 02 дугаар сарын 09-ний өдөр

Байгууллагын нэр:

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК

Нэгжийн нэр:

Барилгын захиалагч, хяналтын хэлтэс

Ажлын байрны нэр:

Хяналтын инженер

Ажлын байрны ангилал, зэрэглэл

Гүйцэтгэх

Ажлын байрны албан ёсны байршил:

ТОСК-ийн байр, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 6-р хороо, Их тойруу 53/3

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЖЛЫН БАЙРНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Ажлын байрны зорилго:

Төслийн хүрээнд гүйцэтгэгч байгууллага болон зөвлөх үйлчилгээний байгууллагатай байгуулсан гэрээг хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг ерөнхий инженертэй хамтран зохион байгуулах, төслийн зохицуулагчид мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг, мэдээлэл өгөх,

Барилгын тухай хууль тогтоомж, норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэх талаар барилгын чанар, үйл ажиллагаанд мэргэжлийн түвшинд хяналт тавих,

барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох асуудлыг холбогдох байгууллагад уламжлах, зөвшөөрлийг авч ажлыг эхлүүлэх, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах, техникийн нөхцөлийг хангагч байгууллагуудаас гаргуулан, барилгын бичиг баримтын бүрдлийг хангаж, үр дүнг хэлтэсийн даргын өмнө хариуцна

Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд компанийн “Авлигын эсрэг бодлогын баримт бичиг”-т тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, үүнтэй холбоотой төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг компанийн хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Ажлын байрын зорилт:

1. Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн ерөнхий гүйцэтгэгч, гэрээт байгууллагуудын барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх, гүйцэтгэлийн чанарт хяналт тавих, захиалагчийн эрх үүргийг хэрэгжүүлж ажиллах;
2. Барилгын тухай хууль болон Барилгын норм ба дүрэм болон бусад дүрэм журам стандартыг баримтлан ажиллах, шаардлагатай зөвшөөрөл бусад баримт бичиг боловсруулах, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн инженерийн тооцоо, техникийн шийдлүүдийн үндэслэл, төлөвлөгөө, тайланг гаргах;
3. Зураг төслийн зохиогчоор төсөл хөтөлбөрүүдэд зохиогчийн хяналт хийсэн тухай тайлан гаргуулж хянах, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэгч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцох, баримтыг боловсруулах, тайлагнах;
4. Төслийн хүрээнд хийгдэх орон сууцны хорооллын барилгын угсралт, гадна инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж, ил болон далд авто зогсоол, гадна зам талбайн тохижилт, ногоон байгууламж, өдөр тутмын үйл ажиллагаа, ажлын байрны аюулгүй орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахиж, захиалагчийн хяналт тавих, барилгын буурь хөрс, суурь хөрсний ус зайлуулах ажилд захиалагчийн хяналт тавьж удирдлагыг мэдээллээр хангах;
5. Бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Ажлын байрын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх-Ш
	Батлагдсан зураг төслийн хүрээнд барилгын ажлын хугацааны графикийн дагуу ажлын явцад өдөр тутмын хяналт гүйцэтгэх.	Батлагдсан зураг төслийн хүрээнд барилгын ажлын хугацааны графикийн дагуу ажлын явцад өдөр тутмын хяналт хийн тайлагнасан байна.	Т, Х, Г
1 дүгээр зорилтын хүрээнд	Улсын төсөв, гадаадын зээл тусламж, төр хувийн хэвшлийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламжийн ажилд техникийн хяналт тавьж, хэмжилт шалгалтыг барилгын салбарт мөрдөж байгаа хууль болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан норм	Улсын төсөв, гадаадын зээл тусламж, төр-хувийн хэвшлийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламжийн ажилд техникийн хяналт тавьж, хэмжилт шалгалтыг барилгын салбарт мөрдөж байгаа хууль	Т, Х, Г

<p>норматив, стандарт, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлэх.</p>	<p>болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан норматив, стандарт, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлэн ажилласан байна.</p>	
<p>Захиалагчийн техник хяналтын гэрээ байгуулсан гүйцэтгэгчийн ажлын явцтай танилцах, захиалагчийн зүгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангасан эсэх талаар үнэлгээ дүгнэлт өгч холбогдох стандарт, норм дүрэм журмын мөрдүүлж, ажлыг гүйцэтгүүлж ажиллах, журналд ажлын явцад гарсан зөрчлийн талаар тэмдэглэл хийх.</p>	<p>Хяналт гүйцэтгэх ажлын чанарт шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллах, журналд ажлын явцад гарсан зөрчлийн талаар тэмдэглэл хийн, баталгаажуулсан байна.</p>	<p>Т, Х, Г</p>
<p>Барилга, инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийн ажилд хэрэглэсэн материал, бүтээцийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораторид нууцалсан дугаар бүхий дээж өгч тодорхойлуулан ил, далд ажлын актыг баталгаажуулах.</p>	<p>Барилга, инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийн ажилд хэрэглэсэн материал, бүтээцийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораторид нууцалсан дугаар бүхий дээж өгч тодорхойлуулан ил, далд ажлын актыг баталгаажуулсан байна.</p>	<p>Т, Х, Г</p>
<p>Ажлын явцад гарсан газар чөлөөлөлт болон техникийн холбогдолтой асуудлуудыг удирдлагад уламжлах, холбогдох байгууллагуудад хүргэх, хэрхэн шийдвэрлэх талаар шийдэл гаргах, шаардлагатай тохиолдолд уулзалтыг зохион байгуулах.</p>	<p>Ажлын явцад гарсан газар чөлөөлөлт болон техникийн холбогдолтой асуудлуудыг удирдлагад уламжлах, холбогдох байгууллагуудад хүргэх, хэрхэн шийдвэрлэх талаар шийдэл гаргах, шаардлагатай тохиолдолд уулзалтыг зохион байгуулж, ажилласан байна.</p>	<p>Т, Х, Г</p>
<p>Төслийн хүрээнд хэрэгжих ажлуудын үе шат тутамд зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх, хамтран ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврын</p>	<p>Төслийн хүрээнд хэрэгжих ажлуудын үе шат тутамд зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх, хамтран ажиллах,</p>	<p>Т, Х, Г</p>

405.1
 Т.Х.Г
 2019110


биелэлтэнд хяналт тавих, хэрэгжүүлэх.	өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэнд хяналт тавих, хэрэгжүүлэн ажилласан байна.	
Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг тогтоосон хугацаанд дүгнэх, гүйцэтгэлийг хянах.	Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг тогтоосон хугацаанд дүгнэх, гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан байна.	Т, Х, Г
Барилга байгууламжийг цаг хугацаанд нь ашиглалтад оруулах тал дээр шаардлагатай бүх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах.	Барилга байгууламжийг цаг хугацаанд нь ашиглалтад оруулах тал дээр шаардлагатай бүх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.	Т, Х, Г
Ашиглагч болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран төслийн хэрэгжилтэнд хяналт тавих, өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх.	Ашиглагч болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран төслийн хэрэгжилтэнд хяналт тавих, өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажилласан байна.	Т, Х, Г
Барилгын ажлын гүйцэтгэлийн мэдээг улирал тутамд гаргаж, барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны болон холбогдох байгууллагад хүргүүлэх.	Барилгын ажлын гүйцэтгэлийн мэдээг улирал тутамд гаргаж, барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны болон холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	Т, Х, Г
Гүйцэтгэгч болон холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх.	Гүйцэтгэгч болон холбогдох байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласан байна.	Т, Х, Г
Барилга угсралтын ажлын явцад техникийн зөрчил гарсан тохиолдолд	Барилга угсралтын ажлын явцад техникийн	Т, Х, Г

	холбогдох байгууллагуудад мэдэгдэх, уулзах, холбогдох зөвшөөрлийг авах, ажлын явцад хяналт тавих, зөрчлийг арилгуулах.	зөрчил гарсан тохиолдолд холбогдох байгууллагуудад мэдэгдэх, уулзах, холбогдох зөвшөөрлийг авах, ажлын явцад хяналт тавих, зөрчлийг арилгуулан, хэвийн ажиллагаанд оруулсан байна.	
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийг чанд баримтлан ажиллах.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийг чанд баримтлан ажиллана.	Т, Х, Г
	Хяналтын болон эрх бүхий байгууллагаас хийсэн үзлэг, шалгалтын дүн, техникийн дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгуулах.	Мэргэжлийн хяналтын болон эрх бүхий байгууллагаас хийсэн үзлэг, шалгалтын дүн, техникийн дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгуулан, дүгнэлтээ гаргуулсан байна.	Т, Х, Г
2 дугаар зорилтын хүрээнд	Гүйцэтгэгч байгууллагын ажлын гүйцэтгэл, чанарт байнга хяналт тавьж илэрсэн зөрчлийг тухай бүрт нь арилгуулах.	Хууль тогтоомж, дүрэм, журам, барилгын нормд нийцүүлэн ажлын гүйцэтгэл, чанарт байнга хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.	Г
	Гүйцэтгэгч байгууллагын гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь хэрхэн гүйцэтгэж байгаад хяналт тавих.	Гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлсэн байдалд хяналт тавин, тайлагнасан байна.	Г
	Хэрэгжиж буй төсөлтэй холбоотой асуудлаар иргэд болон ашиглагч байгууллага гомдол гаргавал өөрийн эрх мэдлийнхээ хүрээнд гүйцэтгэгч байгууллага, нутгийн захиргааны байгууллага болон бусад холбогдох	Аж ахуйн нэгж болон иргэдээс ирүүлсэн гомдолыг шийдвэрлэн тайлагнасан байна.	Г

	харъяа байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх.		
3 дугаар зорилтын хүрээнд	Зураг төсөл зохиогчоор төсөл хөтөлбөрүүдэд зохиогчийн хяналт хийсэн тухай тайлан, дүгнэлтийг гаргуулж авах;	Зураг төсөл зохиогчоор төсөл хөтөлбөрүүдэд зохиогчийн хяналт хийсэн тухай тайлан, дүгнэлтийг гаргуулан авсан байна.	Г
	Барилгын үе шатны ажлыг актаар тухай бүрд баталгаажуулж барилга ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах;	Барилгын үе шатны ажлыг актаар цаг тухайд нь баталгаажуулж, барилга ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд гишүүнээр орж ажилласан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	Барилгын ажлын явцын мэдээг тухай бүрд гарган угсралтын тодорхой хувьд хүрсэн болон шаардлагатай тохиолдолд барилга угсралтын ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах;	Барилгын угсралтын ажлын явцын тайлан мэдээ гаргаж шаардлагатай тохиолдолд барилга угсралтын ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулсан байна.	Г
	Төсөл хөтөлбөрт оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, зардал хэмнэлттэй, өндөр бүтээмж бүхий техник, тоног төхөөрөмжийг сонгон ашиглах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	Төсөл хөтөлбөрт оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг өсгөх чиглэлээр дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх арга хэмжээг судлан зохион байгуулсан байна.	Г
	Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн мэдээ тайланг нэгтгэн баталгаажуулж холбогдох дээд шатны удирдлагад хүргүүлж байх.	Төсөл хөтөлбөрийн мэдээ тайланг удирдлагад тогтмол хугацаанд гаргаж өгсөн байх	Г
	Барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 хоногийн дотор гүйцэтгэгчтэй хамтран баримт бичгийг холбогдох архив болон ашиглагч, гүйцэтгэгч нарт акт үйлдэн хүлээлгэн өгнө	Баримт бичгийг холбогдох архив болон ашиглагч, гүйцэтгэгч нарт акт үйлдэн хүлээлгэн өгсөн байна	Г

	<p>Компаниас гаргасан дүрэм, журам, заавар, Гүйцэтгэх захирлын тушаал, захирлын зөвлөлийн хурлын шийдвэр, шуурхайн үүрэг, даалгавар, шууд удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг зохих шаардлагын дагуу биелүүлэх;</p>	<p>Үүрэг даалгаврыг биелүүлсэн байна</p>	<p>Г</p>
	<p>Авилгын эсрэг хууль тогтоомж, компанийн “Авлигийн эсрэг бодлогын баримт бичиг” төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх, Хөдөлмөрийн дотоод журам, Ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээнд заасан ажлуудыг хийж, хэрэгжүүлэх;</p>	<p>Авилгын эсрэг хууль тогтоомж, компанийн “Авлигийн эсрэг бодлогын баримт бичиг” төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх, Хөдөлмөрийн дотоод журам, Ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээнд заасан авлигын эсрэг холбогдох ажлуудыг хийж хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Г</p>
<p>Ажлын байрны бусад зорилтын хүрээнд</p>	<p>Хариуцсан ажлын чиглэлээр холбогдох байгууллагаас ирүүлсэн удирдамж, баталсан хуваарийн дагуу хийж буй хяналт, шалгалтад шаардлагатай баримт материалыг заасан хугацаанд нь түргэн шуурхай гаргаж өгч бусдад хүндрэл чирэгдэл учруулахгүй ажиллах;</p>	<p>Шаардлагатай баримт, мэдээллийг заасан хугацаанд өгсөн байна.</p>	<p>Г</p>
	<p>Ажлаас чөлөөлөгдөх болон албан тушаал өөрчлөгдөх тохиолдолд эрхэлж байсан ажилтай холбоотой үүссэн цаасан, цахим, тусгай төрлийн баримт бичгийг тухайн онд батлагдсан Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу холбогдох ажилтанд хүлээлгэн өгөх;</p>	<p>Акт үйлдэн хүлээлгэн өгсөн байна.</p>	<p>Г</p>
	<p>Ажлын цагийг үр бүтээлтэй бүрэн ашиглаж, ажлын цагаар ажлаар явах болон түр эзгүй байх үед цагаа бүртгүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх, ажилд ирэх, ажил дуусаж гарахдаа өөрийн биеэр цагаа бүртгүүлж байх, шаардлагатай тохиолдолд илүү цагаар ажиллах;</p>	<p>Ажлын цагаа үр бүтээлтэй ашиглаж, батлагдсан ажлын цагийн хуваарийн дагуу ирцээ цаг тухай бүрт нь бүртгүүлсэн байна.</p>	<p>Г</p>

	Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандарт, байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа хангаж ажиллах;	Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандарт, байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа хангаж ажилласан байна.	Г
III. АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	Иргэний ба үйлдвэрийн барилга, байгууламж /0732/		
Мэргэшил			
Туршлага	Барилгын инженерээр 3-аас доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - бусад. 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Компанийн чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог байх; - Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах - шаардлагатай асуудлаар судалгаа хийж, хариуцах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад. 	
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бусдыг дэмжих, хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад. 	
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг ашиглах; 	

		- бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах.
IV. АЖИЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ		
<u>Ажилтныг шууд харьяалан удирдах Ажлын байрны нэр:</u>		
Барилгын захиалагч, хяналтын хэлтэсийн дарга		
<u>Ажилтны шууд харьяалан удирдуулах ажлын байрны нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u>	
	<ol style="list-style-type: none"> 1. Аймаг, Нийслэлийн төрийн байгууллагуудын холбогдох нэгжүүд 2. Орон нутгийн Барилга захиалагчийн албад 3. Инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагууд 4. Хот байгуулалт, хөгжлийн газар Бусад харилцагч аж ахуйн нэгж байгууллагууд	
Ажилтны хүлээх хариуцлага	- Ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг хэрэгжүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдвол Хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасан хариуцлага хүлээнэ.	
Ажлын байрны нөөц, хэрэгсэл	Санхүү	- Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан үндсэн цалин, удаан жилийн нэмэгдэл, Хөдөлмөрийн хууль болон хамтын гэрээнд заасан бусад нэмэгдлээс бүрдэнэ.
	Материалын	- Албан ерөөний тавилга, эд хогшил, компьютер, холбогдох техник хэрэгсэл - Албан хэрэг хөтлөлтийн програм хангамж
	Бусад	- Ажил хэргийн холбогдолтой ном, гарын авлага - Компанийн вэб сайт, цахим мэдээллийн хэрэгслүүд, дотоод сүлжээ ашиглах;
V. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:		
Албан тушаал: "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлыг түр орлон гүйцэтгэгч		
Гарын үсэг:  Б.ЛХАГВА-ОЧИР		
Ажлын байрны тодорхойлолтыг танилцуулсан:	Ажлын байрны тодорхойлолттой танилцсан:	
Албан тушаал:	Хяналтын инженер	
..... () <u>гарын үсгийн тайлал</u> () <u>гарын үсгийн тайлал</u>	
Огноо:	Огноо:	

